



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/204

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургуульд судалгааны
лаборатори ажиллуулах журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.5 дахь заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Их Сургуульд судалгааны лаборатори ажиллуулах журам"-ыг хавсралтаар баталж 2020 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Журам батлагдсантай холбогдуулан захирлын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/490 дүгээр тушаал, 2012 оны 08 дугаар сарын 31-ний А/425 дугаар тушаал, 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/172 дугаар тушаалаар батлагдсан журмуудыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

3. Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн харьяалалд буй судалгааны лабораториудын харьяаллыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Ахисан түвшний сургуульд бүрэн шилжүүлэхийг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Ч.Лодойравсал/, Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал /Б.Энх-Амгалан/, Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/ нарт үүрэг болгосугай.

4. МУИС-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа лабораториуд энэхүү журмыг баримтлах ба гэрээний хугацаа дуусахад дахин хянан магадалгаа хийхийг Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/-д үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340301775

Захирлын 2020 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Их Сургуульд судалгааны лаборатори ажиллуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын Их Сургуулийн дүрэм, бусад журмуудтай нийцүүлэн энэхүү журмаар зохицуулна.

Судалгааны лаборатори нь судалгааны тодорхой чиглэлээр хэмжилт/туршилт, судалгаа, боловсруулалт, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх хүний нөөц, өрөө, тасалгаа, багаж, тоног төхөөрөмж бүхий орчныг бүрдүүлсэн профессор, багш, пост доктор, ахисан түвшний суралцагчдаас (докторант, магистрант) бүрдсэн хамтлаг байна. Нийгэм, хүмүүнлэгийн салбарт энэхүү журмын шаардлагыг хангасан шинжлэх ухааны тодорхой чиглэлээр байгуулагдсан багийг судалгааны лабораторитой адилтган үзэх бөгөөд лабораторийн багаж, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон өрөө, тасалгаатай байхыг шаардахгүй.

НЭГ. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

1.1 Монгол Улсын Их Сургуулийн стратеги төлөвлөгөө, судалгааны их сургууль болох зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.2 Ахисан түвшний суралцагчдыг судалгааны ажилд татан оролцуулах, тэднийг судалгааны ажил хийх анхан шатны орчин, нөхцөлийг бүрдүүлэх, эрдэм шинжилгээний багц цагийн биелэлт, чанар, үр дүнд хяналт тавин ахисан түвшний сургалтын үйл ажиллагаанд оролцох;


1.3 Ахисан түвшний суралцагчид, пост доктор, залуу багш нарт туршилт, судалгааны ажлын үр чадвар эзэмшүүлэх, судалгааны ажлын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар судалгаанд суурилсан сургалтад оролцох, судалгаа, туршилтын үр дүнгээр бүтээл хэвлэн нийтлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.4 Зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэ дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, оюуны өмчийн баталгаажуулалт хийлгэх;

1.5 Монгол Улсын Их Сургуулийн төсвөөс өөр эх үүсвэрээс санхүүжих судалгааны гэрээт болон захиалгат төсөл, сэдэвт ажил гүйцэтгэх, судалгааны санхүүжилт бүрдүүлэх;

1.6 Мэргэжлийн чиглэлийн дагуу эрдэм шинжилгээний семинар, хурал, симпозиум, түр сургалт зохион байгуулах;

ХОЁР. Судалгааны лаборатори байгуулах



2.1 Монгол Улсын Их Сургуулийн хэмжээнд тухайн шинжлэх ухааны салбарын үндсэн чиглэлийн дагуу Монгол Улсын Их Сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэл давхардахгүйгээр судалгааны лаборатори ажиллуулна.

2.2 Судалгааны лаборатори байгуулах саналыг Монгол Улсын Их Сургуулийн профессорын зэрэглэлийн үндсэн орон тоонд ажиллаж буй багш дэвшүүлэх бөгөөд тухайн шинжлэх ухааны салбарын сургалтыг хариуцаж буй бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн дүгнэлтийг үндэслэн Ахисан түвшний сургууль хянан магадалгаа хийж шийдвэрлэн Монгол Улсын Их Сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3 Монгол Улсын Их Сургуулийн профессор цол хүртсэн үндсэн орон тооны багш энэхүү журмын 2.9-ийг мөрдлөг болгон судалгааны лаборатори байгуулах эрхтэй.

2.4 Бүрэлдэхүүн сургуулийн өөр тэнхимийн багш нар болон хэд хэдэн бүрэлдэхүүн сургуулийн багш нар хамтран салбар дундын судалгааны лаборатори байгуулан ажиллуулж болно.

2.5 Судалгааны лаборатори байгуулах профессор нь сүүлийн 3 жилд гадаад эх үүсвэрээс санхүүжүүлсэн гэрээт эрдэм шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байхыг шаардана.

2.6 Тухайн салбар шинжлэх ухааны нэг чиглэлээр хэд хэдэн профессор судалгааны лаборатори байгуулах санал гаргасан тохиолдолд профессор багш ажиллуулах журмын 7-ийн 8 дахь заалтыг баримтлан Ахисан түвшний сургууль шийдвэрлэнэ.

2.7 Ахисан түвшний сургууль нь шаардлагатай тохиолдолд тодорхой чиглэлээр богино хугацаагаар судалгааны лаборатори байгуулан ажиллуулж болно.

2.8 Судалгааны лаборатори нь удирдлага, зохион байгуулалтын хувьд ахисан түвшний сургуульд, сургалтын бодлогын хувьд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургууль/тэнхимд харьяалагдана.


2.9 Судалгааны лабораторийн бүрэлдэхүүний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- Лабораторийн удирдагч / Профессор -1
- Дэд профессор эсвэл докторын зэрэгтэй ахлах багш - 2
- Пост доктор эсвэл докторант - 1

2.10 Судалгааны лабораторийн удирдагч нь Ахисан түвшний сургуулийн захиралтай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана. Гэрээг Ахисан түвшний сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжсэн нөхцөлд Ахисан түвшний сургуулийн захирал баталгаажуулна.

2.11 Судалгааны лаборатори жилийн эцэст Ахисан түвшний сургуульд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хэлэлцүүлж, дараагийн жилийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг Ахисан түвшний сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

2.12 Судалгааны лабораторийн гишүүн нь өөр судалгааны лабораторид давхар харьяалагдахгүй, хэрэгцээ шаардлага гарсан нөхцөлд гэрээгээр ажиллах бөгөөд энэ тохиолдолд гэрээгээр ажиллаж байгаа лабораторийн орон тоонд тооцогдохгүй.



ГУРАВ. Судалгааны лабораторийн санхүүжилт

3.1 Судалгааны лаборатори нь өөрийгөө санхүүжүүлэх зарчимд үндэслэнэ.

3.2 Судалгааны лабораторид дараах эх үүсвэрүүдээс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

- Ахисан түвшний суралцагчдын тоо, чанарын үзүүлэлтэд үндэслэн тогтоосон судалгааны суурь зардал
- Эрдэм шинжилгээний ажлаас Монгол Улсын Их Сургуульд төвлөрүүлсэн орлогын дахин хуваарилалт
- Ахисан түвшний суралцагчдын эрдэм шинжилгээний багц цагийн төлбөрийн орлогын хуваарилалт
- Пост докторын тэтгэлгийн санхүүжилт
- Ахисан түвшний суралцагчдыг туслахаар ажиллуулах зардал
- Тэтгэлгүүд

ДӨРӨВ. Судалгааны лабораторийн үнэлгээ

4.1 Ахисан түвшний сургууль судалгааны лабораторийн удирдагчийн гаргасан жилийн тайлан, үр дүнгийн гэрээний биелэлт, гишүүдийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл зэргийг үндэслэн Монгол Улсын Их Сургуулийн эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем дэх өгөгдлийг ашиглан ерөнхий үнэлгээ хийнэ.

4.2 Үнэлгээнд Монгол Улсын Их Сургуульд профессор багш ажиллуулах журмын 1-р хавсралтын 2,3-р хүснэгтүүд, ахисан түвшний суралцагчдын үнэлгээг эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцоход баримтлах журам зэргийг баримтална.

4.3 Ерөнхий үнэлгээ нь цаашид тухайн судалгааны лабораторийг дэмжих, чиглэл солих, үйл ажиллагаагаа сайжруулах хугацаатай даалгавар өгөх эсвэл татан буулгах санал оруулах үндэслэл болно.

4.4 Судалгааны лабораторийг татан буулгах, харьяалал өөрчлөх, нэрийг солих шийдвэрийг Ахисан түвшний сургуулийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Ахисан түвшний сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн, Монгол Улсын Их Сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4.5 Судалгааны лаборатори татан буугдсан нөхцөлд тус судалгааны лабораторийн үндсэн хөрөнгийг харьяалагдах бүрэлдэхүүн сургуульд шилжүүлнэ.